



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/369

Булган сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай" А/88 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 тоот хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн хэмжээнд " Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал"-аар нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд удирдлага зохион байгуулалтаар хангах нэгдсэн чиглэл, зөвлөмж, зөвлөн туслах ажлыг хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (аймгийн засаг даргын орлогч)
Гишүүд: М.Батчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Б.Мягмарсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын гарын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Ж.Ганболд (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)
Б.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
Д.Лхагвасүрэн (Татварын хэлтсийн дарга)
Ж.Батзориг (Авто Тээврийн Үндэсний төв, Аж ахуйн
тооцоот ТӨҮГ-ын Булган аймаг дахь газрын дарга)
Нарийн бичгийн дарга: Н.Батжаргал (Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний
газрын дарга)

2.Орон нутгийн түвшинд судалгааны ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3.Судалгааг чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд, Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, судалгаа зохион байгуулсан тухай тайланг судалгаа дууссанаас хойш 14 хоногт багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ